



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 10 сарын 09 өдөр

Дугаар 92

Мандалговь

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаас ТОГТООХ Нь:

Нэг: Хулд сумын Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 34,912,845 (гучин дөрвөн сая есөн зуун арван хоёр мянга найман зуун дөчин тав) тогрогийн балансын үнэ, 11,055,734 (арван нэгэн сая тавин таван мянга долоон зуун гучин дөрөв) төгрөгийн элэгдэл бүхий 64-16 дуа улсын дугаартай УАЗ-патриот маркын автомашинийг Хулд сумын Засаг даргын тамгын газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

Хоёр: Хулд сумын Эрүүл мэндийн төвийн дарга Э.Уранчимэг, Хулд сумын Засаг даргын тамгын газрын дарга С.Сүхдорж нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг сумын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 10-р сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар(С.Ууганбаяр)-т үүрэг болгосугай.

ДАРГА

С.СҮХБААТАР



0100226

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС**

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАРТ

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2018 оны 10 сарын 16 ны өдрийн 14 дугаар хуралдааны тэмдэглэлд:

Дундговь аймгийн Дэрэн сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй нийт 20,000,000 / хорин сая / төгрөгний анхны өртөгтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн УАЗ 390942-018 маркийн ДУА 73-75 улсын дугаартай автомашиныг актлан нээлттэй дуудлага худалдаагаар худалдах саналыг ОНӨГ-ын дарга С.Ууганбаяр танилцуулав.

Дээрх асуудалтай холбогдуулан Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 100% саналаар тогтоолын төслийг дэмжсэнгүй уг автомашиныг Дэрэн сумын ЗДТГ нь засаж сэлбэж өөрийн албан хэрэгцээндээ үргэлжлүүлэн ашиглах нь зүйтэй гэж үзэв” гэжээ



ДАРГА С.СУХБААТАР

С.СУХБААТАР